ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2025/015/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2025 он | Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Даваанями<br>Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn<br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/327

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.САЙНБИЛЭГ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 657.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 937.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 42.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 101.5 сая төгрөг байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 92.2 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6725022104

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 742,593.4 | 836,065.5 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 374,546.6 | 467,860.1 |
| **33** | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 220,651.4 | 204,363.4 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 147,395.4 | 163,842.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 2,309,357.1 | 2,492,581.9 |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 11а, 11б | 102,716.2 | 15,000.0 |
| **37300** | **Урт хугацаат зээл** | | 102,716.2 | 15,000.0 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 2,206,640.9 | 2,477,581.9 |
| **39200** | **Биет хөрөнгө** | | 2,150,575.6 | 2,422,020.6 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 13 | 56,065.3 | 55,561.3 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 3,051,950.5 | 3,328,647.4 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 71,064.3 | 77,321.0 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 71,064.3 | 77,321.0 |
| **41300** | **Өглөг** | 17а, 17б | 71,064.3 | 77,321.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 2,980,886.2 | 3,251,326.4 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 2,980,886.2 | 3,251,326.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 272,121.3 | 610.4 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 249,127.5 | 520,638.4 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 0.0 | 15,211.6 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,251,122.7 | 2,508,053.8 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 208,514.7 | 206,812.2 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 3,051,950.5 | 3,328,647.4 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | 2,282,154.9 | 2,111,372.5 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 515,891.5 | 902,297.7 |
| **110** | **Орлогын албан татвар** | | 312,209.2 | 717,388.8 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | | 347,234.1 | 717,388.8 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | | -35,024.9 | 0.0 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | | 130,790.8 | 120,274.4 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | | 72,891.6 | 64,634.5 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | 549,231.8 | -174,001.0 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 549,231.8 | -175,807.8 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | | 0.0 | 1,806.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 1,217,031.6 | 1,383,075.9 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2а, 2б | 1,791,444.7 | 1,855,468.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 1,791,444.7 | 1,855,468.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,637,140.3 | 1,701,099.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 451,196.1 | 792,600.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 57,222.5 | 98,977.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 5,711.4 | 101,470.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 53,316.6 | 88,257.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 40,294.0 | 120,978.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 3,156.0 | 10,536.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 834,856.7 | 153,891.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 191,387.0 | 334,386.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 154,304.4 | 154,369.4 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | 490,710.2 | 255,904.1 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 39,190.6 | 675.4 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | 451,519.6 | 255,228.6 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 2,409,129.7 | 2,432,856.4 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 515,891.5 | 902,297.7 |
| 110 | Орлогын албан татвар | | 312,209.2 | 717,388.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 347,234.1 | 717,388.8 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -35,024.9 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 130,790.8 | 120,274.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 72,891.6 | 64,634.5 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 14,660.0 | 11,142.5 |
| 1181 | Газрын төлбөр | | 6,298.3 | 7,613.6 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 51,933.2 | 45,878.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 676,206.6 | 147,482.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 676,206.6 | 147,482.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,217,031.6 | 1,383,075.9 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 2,235,453.4 | 1,905,394.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,235,453.4 | 1,905,394.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,946,200.0 | 1,870,821.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 700,872.1 | 974,618.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 92,770.6 | 156,675.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 72,606.8 | 136,950.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 251,340.5 | 292,212.6 |
| 2105 | Нормативт зардал | | 0.0 | 2,350.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 21,300.0 | 120,282.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 3,156.0 | 10,536.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 774,981.0 | 107,002.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 29,173.0 | 70,193.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 289,253.4 | 34,573.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 173,676.3 | 527,462.0 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 166,593.6 | 404,148.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 166,593.6 | 404,148.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 166,593.6 | 404,148.4 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | -166,593.6 | -404,148.4 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | -58,000.0 | -30,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 58,000.0 | 30,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | -50,917.3 | 93,313.5 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 425,463.9 | 374,546.6 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 374,546.6 | 467,860.1 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,529,366.6 | 2,529,366.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,529,366.6 | 2,529,366.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 451,519.6 | 451,519.6 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,980,886.2 | 2,980,886.2 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,980,886.2 | 2,980,886.2 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,702.5 | 1,702.5 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,982,588.7 | 2,982,588.7 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -1,702.5 | -1,702.5 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 15,211.6 | 15,211.6 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 255,228.6 | 255,228.6 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,251,326.4 | 3,251,326.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,414,015.2** | **2,226,629.8** | **418,969.9** | **92.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,876,934.3** | **1,841,833.4** | **34,173.6** | **98.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,865,096.5** | **1,830,038.4** | **34,173.6** | **98.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **814,211.0** | **792,446.0** | **0.0** | **97.3** |
| 210101 | Үндсэн цалин | 432,629.0 | 421,530.2 | 0.0 | **97.4** |
| 210102 | Нэмэгдэл | 308,670.7 | 303,598.5 | 0.0 | **98.4** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,040.0 | 10,315.0 | 0.0 | **93.4** |
| 210104 | Урамшуулал | 61,871.3 | 57,002.3 | 0.0 | **92.1** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **101,776.3** | **98,977.3** | **0.0** | **97.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,333.4 | 67,554.3 | 0.0 | **97.4** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,110.7 | 7,820.1 | 0.0 | **96.4** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,055.4 | 3,910.1 | 0.0 | **96.4** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,055.4 | 3,906.1 | 0.0 | **96.3** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,221.4 | 15,786.8 | 0.0 | **97.3** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **623,934.8** | **623,025.6** | **50,780.4** | **99.9** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 37,378.8 | 36,469.6 | 0.0 | **97.6** |
| 210302 | Түлш, халаалт | 578,456.0 | 578,456.0 | 0.0 | **100.0** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,100.0 | 8,100.0 | 0.0 | **100.0** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **65,017.0** | **64,799.1** | **0.0** | **99.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 13,012.3 | 12,926.7 | 0.0 | **99.3** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,500.0 | 29,472.8 | 0.0 | **99.9** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,664.7 | 4,561.0 | 0.0 | **97.8** |
| 210404 | Ном, хэвлэл | 5,000.0 | 5,000.0 | 0.0 | **100.0** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,840.0 | 12,838.6 | 0.0 | **100.0** |
| **2105** | **Нормативт зардал** | **2,350.0** | **2,350.0** | **0.0** | **100.0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,350.0 | 2,350.0 | 0.0 | **100.0** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **146,086.5** | **146,030.7** | **-18,550.6** | **100.0** |
| 210602 | Тавилга | 25,748.8 | 25,748.7 | -43,497.6 | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 120,337.7 | 120,282.0 | 0.0 | **100.0** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,687.4** | **9,686.0** | **0.0** | **100.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,687.4 | 9,686.0 | 0.0 | **100.0** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **40,301.5** | **38,969.8** | **1,943.8** | **96.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,534.4 | 36,474.8 | 0.0 | **97.2** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 253.0 | 252.5 | 0.0 | **99.8** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 307.8 | 186.8 | 0.0 | **60.7** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77.0 | 0.0 | 0.0 | **0.0** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,800.0 | 1,800.0 | 0.0 | **100.0** |
| 210807 | Газрын төлбөр | 329.3 | 255.8 | 0.0 | **77.7** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **61,732.0** | **53,753.9** | **0.0** | **87.1** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,000.0 | 43,124.8 | 0.0 | **84.6** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,732.0 | 10,629.1 | 0.0 | **99.0** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,837.8** | **11,795.0** | **0.0** | **99.6** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **11,837.8** | **11,795.0** | **0.0** | **99.6** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,837.8 | 11,795.0 | 0.0 | **99.6** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **444,942.3** | **354,796.4** | **354,796.4** | **79.7** |
| 223001 | Бусад хөрөнгө | 444,942.3 | 354,796.4 | 0.0 | **79.7** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **92,138.6** | **30,000.0** | **30,000.0** | **32.6** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 92,138.6 | 30,000.0 | 0.0 | **32.6** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,414,015.2** | **2,228,772.7** | **-185,242.4** | **92.3** |
| **310001** | **Улсын төсвөөс санхүүжих** | **200,438.9** | **-** | **200,438.9** | **-** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 200,438.9 | - | 200,438.9 | - |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,774,503.1** | **2,170,063.4** | **-395,560.3** | **122.3** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,774,503.1 | 1,969,624.5 | -195,121.4 | **111.0** |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | 200,438.9 | -200,438.9 | - |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **439,073.2** | **58,709.4** | **380,363.8** | **13.4** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,000.0 | 53,502.9 | -8,502.9 | **118.9** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000.0 | 5,206.5 | 793.5 | **86.8** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 388,073.2 | 0.0 | 388,073.2 | **0.0** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 132,636.9 | 132,636.9 | **0.0** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 134,779.9 | 134,779.9 | **0.0** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **0.1** | **0.1** | **0.1** | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **3.0** | **3.0** | **0.0** | **100.0** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2.0 | 2.0 | 0.0 | **100.0** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.0 | 1.0 | 0.0 | **100.0** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **3.0** | **3.0** | **0.0** | **100.0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1.0 | 1.0 | 0.0 | **100.0** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1.0 | 1.0 | 0.0 | **100.0** |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1.0 | 1.0 | 0.0 | **100.0** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **65,688.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **65,688.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **42,875.17** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,584.67** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,784.67 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **850.50** |
| 210702 | Дотоод албан томилолт | 850.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,440.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,440.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,813.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,778.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,778.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **35.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 35.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **65,688.17** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **65,688.17** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000.00 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,653.17 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сан, 1 ААН, нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар дүгнэлт гаргаж, Тосон-Илч ОНӨҮГ-ын санхүүгийн тайланд Ихэрмөрөн-Аудит ХХК дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Тосонцэнгэл сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн.

**5.1 Зөвлөмж** Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

1.1. Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, төсвийн сахилга баттай холбоотой 1.2 сая төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах талаар 1 зөвлөмж, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Өгсөн зөвлөмж: Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

2. **Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр хангаж биелүүлэх талаар:**

2.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 4 нэр төрлийн 15.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр хангаж биелүүлж ажиллах.

3. **Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой:**

3.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 101.5 сая төгрөг байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "*Хоршоо хөгжүүлэх сангийн журам*"-ын 3.4.11-д "*Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ*" гэсэн заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харьяа байгууллагуудын залруулсан алдаа | | | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 1.7 | | | 1 | 1.7 | 1 | 1.7 | | |
| **Дүн** | **1** | **1.7** | | | **1** | **1.7** | **1** | **1.7** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах АШ | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Хүний тоо | Тоо | Дүн |
| ХХС хугацаа хэтэрсэн зээл | 1 | 101.5 | | | | | 1 | 101.5 | | | | |
| Орлогыг нэр төрлөөр нь ханган биелүүлээгүй | 1 | 15.4 | | | | | 1 | 15.4 | | | | |
| **Нийт дүн** | **2** | **116.9** | | | | | **2** | **116.9** | | | | |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 2 | 1.2 | 1 | 1.2 | | | 1 | 0 | | | | |
| **Нийт дүн** | **2** | **1.2** | **1** | **1.2** | | | **1** | **0** | | | | |